



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын 2025 оны  
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** САГ-2026/27/НА-СТА-ТЕЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Улаанбаатар хот  
2026 он

Тусгай чиг үүргийн аудитын газрын захирал,  
Тэргүүлэх аудитор: Д.Баярсайхан  
Цахим хаяг: bayarsaikhand@audit.gov.mn

Аудитын менежер: А.Цогбаяр  
Утас: 261628 Цахим хаяг: tsogbayara@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Ариунжаргал  
Утас: 261628 Цахим хаяг: ariunjargalb@audit.gov.mn

Аудитор: Д.Номингуа  
Утас: 261628 Цахим хаяг: nominguad@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

<b>1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....</b>	<b>3</b>
<b>2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН ..</b>	<b>6</b>
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	6
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	7
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	12
<b>3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА .....</b>	<b>13</b>
3.1 Төсвийн ерөнхийлөн захирагч:	13
3.2 Төсвийн ерөнхийлөн захирагчийн хууль эрх зүйн орчин	14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	14
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	14
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	15
3.5.1 Төсвийн төлөвлөлт	16
3.5.2 Төсвийн гүйцэтгэл	16
3.5.3 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл	18
<b>4. АУДИТЫН ТАЙЛАН .....</b>	<b>19</b>
4.1 Ерөнхий зүйл	19
4.2 Материаллаг байдал	20
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	20
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	20
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	20
4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд	21
4.5 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн	22
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	22
<b>5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....</b>	<b>23</b>
5.1 Албан шаардлага	23
5.2 Зөвлөмж	24
<b>6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....</b>	<b>25</b>
6.1 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл	25
6.2 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	26

#### **Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
САГ	Санхүүгийн аудитын газар
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТЕГ	Тагнуулын ерөнхий газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ҮАГ	Үндэсний аудитын газар
ЦАУЗБУК	Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комисс



**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОР**

Засгийн газрын IV байр, Бага тойруу-3,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160  
Утас: 26-04-37, Факс: (976-51) 26 42 30  
Цахим шуудан: info@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

ЦАГААТГАХ АЖЛЫГ УДИРДАН  
ЗОХИОН БАЙГУУЛАХ УЛСЫН КОМИССЫН  
ДАРГА Б.ПҮРЭВДОРЖ ТАНАА

2026.04.24 № 1130  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын даргын төсвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын даргын төсвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, болон үр дүн, мөнгөн гүйлгээний тайлангууд, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

**Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн залруулагдаагүй нийт 44.2 сая төгрөгийн зөрчил бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаараа болон нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Тухайлбал:

- Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн нийт 15.1 сая төгрөгийн хөрөнгийн асуудлыг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт тавьж шийдвэрлүүлэх арга хэмжээ аваагүй;
- Анхан шатны баримтын бүрдэл дутуу, нотлох баримтын шаардлага хангаагүй байхад засвар үйлчилгээний зардалд нийт 10.5 сая төгрөгийг зарцуулсан.

Эдгээр зөрчил нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3, 41 дүгээр зүйлийн 41.2.6, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6, 13.7, 20 дугаар зүйлийн 20.1.4, 20.2.3, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр

тогтоолын "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 7.1 заалтуудтай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын "үнэлгээ ба хуваарилалт", "нийцсэн ба зохистой байх" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

### **Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж, Улсын комиссын дүрэм болон бусад хууль тогтоомжийн хүрээнд Иргэний хэргийн анхан шатны шүүхээс гаргасан шийдвэрийн дагуу тайлант онд 322.0 сая төгрөгийн нөхөх олговор олгохоор батлагдаж, гүйцэтгэлээр 7 иргэнд 322.0 сая төгрөгийн нөхөх олговрыг олгосон байна.

### **Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант онд Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөн олговор олгох тухай хууль, Үндэсний Аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд Тагнуулын ерөнхий газрын Мөрдөн шалгах газарт ажиллаж буй гэрээт мөрдөгчдийг хөлсөөр ажиллуулан 105.2 сая төгрөгийг зарцуулж, нийт 202 хүнд холбогдох 148 хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулсан байна.

### **Бусад асуудал**

Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комисс нь тайлант онд их, дээд сургууль, ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчид, оюутан залуучуудад "Монголд өрнөсөн улс төрийн хэлмэгдүүлэлт: дүгнэлт, сургамж", "Алтан ургийн угсааны ноёдын хэлмэгдүүлэлтийн талаар" нийт 8 удаагийн сургалтыг зохион байгуулж, нийт 420 гаруй оюутан, сурагчдыг хамруулжээ. Тус байгууллага нь эрдэм шинжилгээний бага хурлын эмхэтгэл, "Амьдрал ба хэлмэгдүүлэлт", "Алтан ургийн хаад ноёд" гэх мэт 4 судалгааны ажил, ном бүтээлийг судлаачид, төрийн бус байгууллагатай хамтран гаргаж олон нийтийн хүртээл болгосон байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.



С.МАГНАЙСҮРЭН

## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Тайлангийн үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
I	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	54,730,233.00	38,258,131.21
33	АВЛАГА	-	887,132.21
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	887,132.21
34	УРЬДЧИЛГАА	18,260,000.00	-
34600	Урьдчилж гарсан зардал	18,260,000.00	-
35	БАРАА МАТЕРИАЛ	36,470,233.00	37,370,999.00
35400	Хангамжийн материал	36,470,233.00	37,370,999.00
35410	Бичиг хэргийн материал	3,825,200.00	280,000.00
35420	Аж ахуйн материал	1,045,500.00	1,221,500.00
35470	Бусад хангамжийн материал	31,599,533.00	35,869,499.00
II	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	44,687,319.28	26,359,327.96
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	44,687,319.28	26,359,327.96
39200	Биет хөрөнгө	42,960,152.58	26,359,327.96
39203	Авто-тээврийн хэрэгсэл	15,948,330.00	15,948,330.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(664,513.75)	(8,638,678.75)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	26,011,246.00	30,507,386.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(14,806,092.16)	(22,931,463.85)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	14,147,890.00	13,984,790.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(6,141,441.51)	(8,906,109.44)
39217	Ном	8,464,734.00	6,395,074.00
39300	Биет бус хөрөнгө	1,727,166.70	-
39301	Программ хангамж	3,526,000.00	2,736,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,798,833.30)	(2,736,000.00)
III	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	99,417,552.28	64,617,459.17
V	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	99,417,552.28	64,617,459.17
51	Засгийн газрын хувь оролцоо	99,417,552.28	64,617,459.17
51100	Засгийн газрын оруулсан капитал	50,239,441.00	50,239,441.00
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө	50,239,441.00	50,239,441.00
51200	Хуримтлагдсан үр дүн	49,178,111.28	14,378,018.17
51210	Өмнөх үеийн үр дүн	23,187,279.50	49,178,111.28
51220	Тайлант үеийн үр дүн	25,990,831.78	(34,800,093.11)
VI	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	99,417,552.28	64,617,459.17

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Тайлангийн үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	8,334,422,330.00	1,184,002,100.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	19,846,930.00	1,184,002,100.00
120	Нийтлэг татварын бус орлого	19,846,930.00	-
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	19,846,930.00	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	19,846,930.00	-
122	Тусламжийн орлого	-	1,184,002,100.00
1221	Хандив тусламж /дотоод/	-	1,184,002,100.00
12211	Харьяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого	-	1,184,002,100.00
122111	Урсгал санхүүжилтийн орлого\	-	1,184,002,100.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	8,314,575,400.00	-
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	8,314,575,400.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	8,314,575,400.00	-
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	8,308,431,498.22	1,216,295,550.01
21	УРСГАЛ ЗАРДАЛ	8,308,431,498.22	1,216,295,550.01
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	858,234,311.02	852,635,823.93
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	384,542,715.65	449,803,176.84
210101	Үндсэн цалин	227,988,928.68	232,430,108.73
210102	Нэмэгдэл	83,932,441.42	114,809,788.11
210103	Унаа хоолны хөнгөлөлт	43,119,000.00	71,449,000.00
210104	Урамшуулал	29,502,345.55	31,114,280.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	45,373,800.00	56,944,412.94
210201	Тэтгэврийн даатгал	30,854,200.00	38,825,178.31
210202	Тэтгэмжийн даатгал	3,629,900.00	4,567,709.28
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,990,739.88	2,260,350.45
210204	Ажилгүйдлийн даатгал	1,639,060.12	2,456,756.36
210205	Эрүүл мэндийн даатгал	7,259,900.00	8,834,418.54
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	41,204,000.00	40,734,000.00
210304	Байрны түрээс	41,204,000.00	40,734,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	38,078,561.55	23,872,933.02
210401	Бичиг хэрэг	5,890,400.00	9,872,100.00
210402	Тээвэр, шатахуун	6,400,000.00	2,150,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,870,599.55	7,211,933.02
210404	Ном, хэвлэл	5,100,000.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	11,302,496.00	4,638,900.00
210408	Бараа материал акталсны зардал	5,515,066.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,922,500.00	1,281,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,903,500.00	-
210604	Урсгал засвар	6,019,000.00	1,281,000.00
2107	Томилолт, зочны зардал	69,089,597.00	8,173,200.00
210701	Гадаад албан томилолт	41,726,000.00	4,974,200.00

Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын 2025 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210702	Дотоод албан томилолт	17,460,460.00	3,199,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	9,903,137.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	236,642,785.60	245,121,618.91
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	227,188,285.60	210,564,018.91
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	9,454,500.00	34,557,600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	34,380,351.22	26,705,482.22
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,070,595.00	1,680,234.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	14,140,000.00	2,800,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	11,169,756.22	22,225,248.22
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,450,197,187.20	363,659,726.08
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	7,866,868.88
21311	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	7,866,868.88
213112	Төсвийн байгууллагаас харьяа төрийн сан руу төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	7,866,868.88
2131121	Санхүүжилтийг үлдэгдлээс төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	7,866,868.88
2132	Бусад урсгал шилжүүлэг	7,426,168,800.00	355,792,857.20
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	23,868,800.00	1,550,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	7,402,300,000.00	322,000,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	32,242,857.20
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	24,028,387.20	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	24,028,387.20	-
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	25,990,831.78	(32,293,450.01)
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	2,506,643.10
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	-	2,506,643.10
VII	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)	-	(2,506,643.10)
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	25,990,831.78	(34,800,093.11)

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны нэр, төрөл	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	50,239,441.00	-	23,187,279.50	73,426,720.50
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	50,239,441.00	-	23,187,279.50	73,426,720.50
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	25,990,831.78	25,990,831.78
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	50,239,441.00	-	49,178,111.28	99,417,552.28
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	50,239,441.00	-	49,178,111.28	99,417,552.28
Тайлант үеийн үр дүн	-	-	(34,800,093.11)	(34,800,093.11)
2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	50,239,441.00	-	14,378,018.17	64,617,459.17

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Тайлангийн үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	8,314,575,400.00	1,184,002,100.00
12	Татварын бус орлого	-	1,184,002,100.00
122	Тусламжийн орлого	-	1,184,002,100.00
1221	Хандив тусламж /дотоод/	-	1,184,002,100.00
12211	Харьяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого	-	1,184,002,100.00
122111	Урсгал санхүүжилтийн орлого\	-	1,184,002,100.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	8,314,575,400.00	-
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	8,314,575,400.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	8,314,575,400.00	-
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	8,307,286,000.00	1,177,598,200.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	8,307,286,000.00	1,177,598,200.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	857,088,812.80	813,938,473.92
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	384,542,715.65	450,690,308.90
210101	Үндсэн цалин	227,988,928.68	236,276,988.15
210102	Нэмэгдэл	83,932,441.42	111,850,040.75
210103	Унаа хоолны хөнгөлөлт	43,119,000.00	71,449,000.00
210104	Урамшуулал	29,502,345.55	31,114,280.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	45,373,800.00	56,944,413.09
210201	Тэтгэврийн даатгал	30,854,200.00	38,825,178.36
210202	Тэтгэмжийн даатгал	3,629,900.00	4,567,709.28
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,814,900.00	2,467,758.02
210204	Ажилгүйдлийн даатгал	1,814,900.00	2,249,348.89
210205	Эрүүл мэндийн даатгал	7,259,900.00	8,834,418.54
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	41,204,000.00	40,734,000.00
210304	Байрны түрээс	41,204,000.00	40,734,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	31,282,619.55	20,573,533.02
210401	Бичиг хэрэг	5,003,900.00	6,087,900.00
210402	Тээвэр, шатахуун	5,400,000.00	3,010,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,290,599.55	6,351,933.02
210404	Ном, хэвлэл	7,260,000.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,328,120.00	5,123,700.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,318,500.00	2,281,300.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,299,500.00	1,000,300.00
210604	Урсгал засвар	6,019,000.00	1,281,000.00

Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын 2025 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2107	Томилолт, зочны зардал	69,089,597.00	8,173,200.00
210701	Гадаад албан томилолт	41,726,000.00	4,974,200.00
210702	Дотоод албан томилолт	17,460,460.00	3,199,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	9,903,137.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	253,066,985.60	230,091,718.91
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	243,222,285.60	194,146,518.91
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	9,844,700.00	35,945,200.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	23,210,595.00	4,450,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,070,595.00	1,650,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	14,140,000.00	2,800,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,450,197,187.20	363,659,726.08
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	7,866,868.88
21311	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	7,866,868.88
213112	Төсвийн байгууллагаас харьяа төрийн сан руу төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	7,866,868.88
2131121	Санхүүжилтийг үлдэгдлээс төвлөрүүлэх шилжүүлгийн зардал\	-	7,866,868.88
2132	Бусад урсгал шилжүүлэг	7,426,168,800.00	355,792,857.20
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	23,868,800.00	1,550,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	7,402,300,000.00	322,000,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	32,242,857.20
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	24,028,387.20	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	24,028,387.20	-
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	7,289,400.00	6,403,900.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	7,289,400.00	6,403,900.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	7,289,400.00	6,403,900.00
2200	Дотоод эх үүсвэрээр	7,289,400.00	6,403,900.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	7,289,400.00	6,403,900.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(7,289,400.00)	(6,403,900.00)

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	1,225,820,900.00	1,176,135,231.12	49,685,668.88	95.9
Татварын бус орлого	1,225,820,900.00	1,176,135,231.12	49,685,668.88	95.9
Тусламжийн орлого	1,225,820,900.00	1,176,135,231.12	49,685,668.88	95.9
Төсвөөс санхүүжих	1,225,820,900.00	1,176,135,231.12	49,685,668.88	95.9
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,225,820,900.00	1,176,135,231.12	49,685,668.88	95.9
УРСГАЛ ЗАРДАЛ	1,225,820,900.00	1,176,135,231.12	49,685,668.88	95.9
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	868,546,700.00	820,342,373.92	48,204,326.08	94.5
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	465,178,400.00	450,690,308.90	14,488,091.10	96.9
Үндсэн цалин	238,551,100.00	236,276,988.15	2,274,111.85	99.0
Нэмэгдэл	113,198,000.00	111,850,040.75	1,347,959.25	98.8
Унаа хоолны хөнгөлөлт	74,173,000.00	71,449,000.00	2,724,000.00	96.3
Урамшуулал	39,256,300.00	31,114,280.00	8,142,020.00	79.3
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	58,985,100.00	56,944,413.09	2,040,686.91	96.5
Тэтгэврийн даатгал	40,115,800.00	38,825,178.36	1,290,621.64	96.8
Тэтгэмжийн даатгал	4,719,500.00	4,567,709.28	151,790.72	96.8
ҮОМШӨ-ний даатгал	2,367,000.00	2,467,758.02	(100,758.02)	104.3
Ажилгүйдлийн даатгал	2,356,600.00	2,249,348.89	107,251.11	95.4
Эрүүл мэндийн даатгал	9,426,200.00	8,834,418.54	591,781.46	93.7
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	40,807,500.00	40,734,000.00	73,500.00	99.8
Байрны түрээс	40,807,500.00	40,734,000.00	73,500.00	99.8
Хангамж, бараа материалын зардал	24,371,700.00	20,573,533.02	3,798,166.98	84.4
Бичиг хэрэг	6,501,600.00	6,087,900.00	413,700.00	93.6
Тээвэр, шатахуун	4,881,400.00	3,010,000.00	1,871,400.00	61.7
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,468,900.00	6,351,933.02	1,116,966.98	85.0
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,519,800.00	5,123,700.00	396,100.00	92.8
Эд хогшил, урсгал засварын зардал	10,561,200.00	8,685,200.00	1,876,000.00	82.2
Багаж, техник, хэрэгсэл	9,055,200.00	7,404,200.00	1,651,000.00	81.8
Урсгал засвар	1,506,000.00	1,281,000.00	225,000.00	85.1
Томилолт, зочны зардал	8,173,200.00	8,173,200.00	-	100.0
Гадаад албан томилолт	4,974,200.00	4,974,200.00	-	100.0
Дотоод албан томилолт	3,199,000.00	3,199,000.00	-	100.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	256,019,600.00	230,091,718.91	25,927,881.09	89.9
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил	220,074,400.00	194,146,518.91	25,927,881.09	88.2

Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын 2025 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

үйлчилгээний төлбөр хураамж				
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	35,945,200.00	35,945,200.00	-	100.0
Бараа үйлчилгээний бусад зардал	4,450,000.00	4,450,000.00	-	100.0
Бараа үйлчилгээний бусад зардал	1,650,000.00	1,650,000.00	-	100.0
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,800,000.00	2,800,000.00	-	100.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	357,274,200.00	355,792,857.20	1,481,342.80	99.6
Бусад урсгал шилжүүлэг	357,274,200.00	355,792,857.20	1,481,342.80	99.6
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,550,000.00	1,550,000.00	-	100.0
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	322,000,000.00	322,000,000.00	-	100.0
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	33,724,200.00	32,242,857.20	1,481,342.80	95.6
ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	-	-	-	-
АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	-	-	-
Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	-	-	-	-
БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	100.0
Төсвийн байгууллага	1	1	-	100.0
АЖИЛЛАГСДЫН ТОО	11	10	-1	90.9
Удирдах ажилтан	1	1	-	100.0
Гүйцэтгэх ажилтан	10	9	-1	90.9

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Төсвийн ерөнхийлөн захирагч:

Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комисс нь язгуур угсаа, гарал үүсэл, үзэл бодол, шашин шүтлэг, хөрөнгө чинээ, нийгмийн байдлын улмаас улс төрийн хэрэгт хилсээр шийтгэгдсэн, нам, захиргааны байгууллагаас арга хэмжээ авагдсан, хэлмэгдсэн иргэдийн асуудлыг судалж шалгах, хянаж зохион байгуулах үүрэг бүхий цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах үйл ажиллагааг эрхэлдэг байгууллага юм.

Тус комиссын зорилтыг дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

- Төрийн эсрэг гэмт хэрэг үйлдсэн, нам, төрийн бодлого, шийдвэрт шүүмжлэлтэй хандсан гэх шалтгаанаар хилсээр шийтгүүлсэн, нам, захиргааны байгууллагаас хилсээр арга хэмжээ авагдсан иргэдийн хэргийг шалгаж, шийдвэрлүүлэх, хэлмэгдсэн иргэнд хууль, тогтоомжийн дагуу тэтгэмж, тусламж, нөхөн олговор олгуулах;
- Хэлмэгдэгсдийн нэр төрийг сэргээн сурталчлахад холбогдох байгууллага, албан тушаалтан, иргэдийг татан оролцуулах, улс төрийн хэлмэгдүүлэлтийн уршигт үр дагаврыг арилгах зэрэг ажлуудыг зохион байгуулахад оршино.

### 3.2 Төсвийн ерөнхийлөн захирагчийн хууль эрх зүйн орчин

Тайлант хугацаанд төсвийн ерөнхийлөн захирагчийн үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг дараах хууль тогтоомж болон бодлого, чиглэлд өөрчлөлт орсон байна. Тухайлбал:

- Төсвийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.5 заалт;
- Төрийн албаны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.8 заалт;
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1, 13.1.2 дахь заалтыг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсөн;
- Монгол Улсын Их Хурлын 2025 оны “Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай” 48 дугаар тогтоол;
- Монгол Улсын Засгийн Газрын 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн “Улсын үзлэг зохион байгуулах тухай” 23 дугаар тогтоол;
- Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”;
- Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн “Засгийн газраас шуурхай авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 04, 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн “Төсвийн сахилга бат, хариуцлагыг чангатгах тухай” 05 дугаар албан даалгаврууд гаргасан;

Удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөө багатай байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авч санхүүгийн үйл ажиллагаанд хяналт хангалтгүй учир дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

ЦАУЗБУК-ын 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил, гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

ЦАУЗБУК-ын нарийн бичгийн даргын 2022 оны А/13 дугаар тушаалаар холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулж батлуулсан ч үйл ажиллагааны онцлогт бүрэн нийцээгүй байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

ЦАУЗБУК-ын даргын 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 34.8 сая төгрөгөөр буюу 35.0 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	-	0.9	0.9
Урьдчилгаа	18.3	-	(18.3)
Бараа материал	36.5	37.4	0.9
Үндсэн хөрөнгө	44.7	26.4	(18.3)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>99.4</b>	<b>64.6</b>	<b>(34.8)</b>
Засгийн газрын хувь оролцоо	99.4	64.6	(34.8)
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>99.4</b>	<b>99.4</b>	<b>(34.8)</b>

Эх сурвалж: ЦАУЗБУК-ын даргын 2025 оны санхүүгийн тайлан

Дээрх хүснэгтээс харахад, нөлөө бүхий өөрчлөлт гарсан засгийн газрын хувь оролцоо, урьдчилгаа, үндсэн хөрөнгө, авлага, бараа материал данснууд байна. Үүнд:

- Урьдчилгаа дансны эхний үлдэгдэл 18.3 сая төгрөг нь Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуулийг олон нийтэд таниулах, хэлмэгдүүлэлтийн бусад үр дагаврыг арилгах зэрэг хуульд заасан үндсэн чиг үүргийг таниулах зорилгоор хийлгэсэн баримтат нэвтрүүлэг, сурталчилгаа, дүрст бичлэгийг 2025 оны 01 дүгээр улиралд олон нийтийн цахим сүлжээ болон олон нийтийн радио, телевизээр түгээх ажлын төлбөр “Дэлхийн чимээ медиа групп”-д 8.3 сая төгрөг, “Фило” компанид 7.8 сая төгрөг, “Бит пресс” компанид ном хэвлүүлэхээр 2.2 сая төгрөг байсан бөгөөд тайланд онд гүйцэтгэж, зардлаар хүлээн зөвшөөрсөн байна.
- Үндсэн хөрөнгийн үлдэгдэл 26.4 сая төгрөг болж, өмнөх оноос 18.3 сая төгрөгөөр буурсан нь 6.3 сая төгрөгийн хөрөнгө худалдан авсан, ТӨБЗГ-ын 2025 оны 489 дүгээр тогтоолоор ажлын албаны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, ашиглалтын шаардлага хангахгүй 13 нэрийн нийт 4.9 сая төгрөгийн балансын үнэ бүхий хөрөнгийг акталж, тайлант оны 25.0 сая төгрөгийн элэгдлээр буурсан зэргээс шалтгаалжээ.
- Авлага дансны үлдэгдэл 0.9 сая төгрөгөөр өссөн нь ажиллагчидтай холбогдсон авлагын нэмэгдсэнтэй холбоотой байна.
- Бараа материалын үлдэгдэл 37.4 сая төгрөг болж, өмнөх оноос 0.9 сая төгрөгөөр өссөн нь тайлант онд худалдаж авсан 5.9 сая төгрөгийн бичиг хэрэг, 7.9 сая төгрөгийн аж ахуйн материал, 3.0 сая төгрөгийн түлш шатахуун, 6.7 сая төгрөгийн бусад хангамжийн материалаар нэмэгдэж, 22.6 сая төгрөгийн бараа материалыг зарцуулсантай холбоотой байна.
- Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 64.6 сая төгрөг болсон нь тайлант оны үр дүн 34.8 сая төгрөгөөр буурсантай холбоотой байна.
- ЦАУЗБУК нь нягтлан бодох бүртгэлийн “Акколоус” программ ашигладаг бөгөөд санхүүгийн тайланд 0.2 сая төгрөгөөр бүртгэлтэй байна. Тайлант онд санхүүгийн тооцоолох программын лицензийн төлбөрт 0.5 сая төгрөгийг зарцуулсан.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д заасны дагуу төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсгийг ирүүлэхээр заасны дагуу тус ерөнхийлөн захирагчийн төсвийн гүйцэтгэлийн тайланд хамаарах тухайн жилийн төсвийн орлого, зарлагын гүйцэтгэл /нийт дүнгээр, хөтөлбөрөөр, төсвийн захирагчаар, хөрөнгө оруулалтын арга хэмжээ бүрээр/, тухайн жил худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэл, хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүн, түүний танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн

хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/, нэмэлт төсвийн гүйцэтгэл, түүний танилцуулгыг хавсаргаж ирүүлсэн байна.

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.2-д заасны дагуу ЦАУЗБУК нь 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,476.7 сая төгрөгийн санхүүжилт авахаар төлөвлөж Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлсэн байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн хүргүүлсэн төсвийн саналаас томилолт, зочны зардлыг 46.9 сая төгрөгөөр, хэлмэгдэгсэд, тэдний ар гэрт олгох нөхөх олговрын зардлыг 33.0 сая төгрөгөөр, түүх, соёлын дурсгалт зүйлсийг хамгаалах зардлыг 30.0 сая төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардлыг 25.5 сая төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийг 22.6 сая төгрөгөөр, хангамж, бараа материалын зардлыг 15.4 сая төгрөгөөр, ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал зардлыг 12.7 сая төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 8.4 сая төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 5.4 сая төгрөгөөр, нийт 199.9 сая төгрөгөөр бууруулж, цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардлыг 18.5 сая төгрөгөөр, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 14.9 сая төгрөгөөр, нийт 33.4 сая төгрөгөөр нэмэгдүүлж, зардлын эх үүсвэрийг 1,310.2 сая төгрөгөөр баталжээ.

Төсвийн тодотголоор улсын төсвөөс санхүүжих эх үүсвэрийг 84.4 сая төгрөгөөр бууруулж, урсгал үйл ажиллагааны зардлыг 868.5 сая төгрөг, бусад урсгал шилжүүлгийг 357.3 төгрөг, нийт 1,225.8 сая төгрөгөөр баталжээ.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг улсын төсвөөс 1,225.8 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр батлагдаж, гүйцэтгэлээр 1,184.0 сая төгрөгийн санхүүжилт олгож, үйл ажиллагааны зардалд 820.3 сая төгрөг, хэлмэгдэгсэд, тэдний ар гэрт олгох тэтгэмжийн зардалд 322.0 сая төгрөг, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжид 32.2 сая төгрөг, ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулалд 1.5 сая төгрөг, нийт 1,176.1 сая төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 7.9 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлжээ.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, зориулалтын төлөвлөгөө, гүйцэтгэл /сая төгрөгөөр/*

Хөтөлбөр, арга хэмжээ		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт /хувь/
Код	Нэр				
72204	Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсэд	1,225.8	1,176.1	49.7	95.9
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	648.5	626.2	22.3	96.6
80103	Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээний зардал	137.6	112.2	25.4	81.5
80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	35.3	33.8	1.5	95.8
80818	Хэлмэгдэгсэд тэдний ар гэрт олгох тэтгэмж	322.0	322.0	-	100
81569	Түүх, соёлын дурсгалт зүйлсийг хамгаалах	82.5	82.0	0.5	99.4

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан “Төрийн аудитын байгууллагаас төсвийн тухай хуулийн дагуу 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах ерөнхий чиглэл”-ийн дагуу шалгагдагч байгууллагаас 6 төрлийн судалгаа авсан. Үүнд:

1. Байгууллагын орон тооны цомхотгол: “Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 54 дүгээр тогтоолын 1 дэх хэсэгт заасныг хэрэгжүүлж, төсөвт байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардлыг арилгаж оновчтой болгох, төрийн үйлчилгээний цахимжилтыг эрчимжүүлэх, ажлын ачааллыг нягтруулах, бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор “Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө”-нд туссан багш, эмч нараас бусад төрийн албан хаагчийг орон тоог 9 хувиар бууруулах арга хэмжээг 2025 онд эхлүүлсэн. ЦАУЗБУК-н орон тоог ЦАУЗБУК-ын даргын 2022 оны 07 дугаар “Дотоод журам, бүтэц, орон тооны хязгаар батлах тухай” захирамжаар орон тооны хязгаарыг 11 байхаар баталжээ. ЦАУЗБУК-ын нарийн бичгийн даргын 2025 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн Б/47 дугаар тушаалаар 1 ажилтныг үүрэгт ажлаас чөлөөлж, 10 орон тоогоор ажилласан байна. Тайлант онд цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардалд нийт 465.2 сая төгрөгийг төлөвлөж, гүйцэтгэлээр 450.7 сая төгрөгийг олгож, 14.5 сая төгрөгөөр дутуу зарцуулжээ.
2. ЦАУЗБУК-ын нарийн бичгийн даргын “Албан хаагчдад нийтийн тээврийн унааны болон өдрийн хоолны зардлын нөхөх төлбөр олгох тухай” 2025 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн Б/14 дугаар тушаалаар албан хаагчдад нэг өдөрт олгох унааны зардлыг 2.0 мянган төгрөгөөр, хоолны зардлыг 30.0 мянган төгрөгөөр тус тус баталжээ. Тайлант онд унаа, хоолны хөнгөлөлтийн зардалд нийт 74.2 сая төгрөгийг төлөвлөж, гүйцэтгэлээр 71.5 сая төгрөгийг олгож, 2.7 сая төгрөгөөр дутуу зарцуулжээ.
3. Гадаад албан томилолтын зардалд 5.0 сая төгрөг батлагдаж, тайлант онд бүрэн зарцуулжээ. ЦАУЗБУК-ын даргын 2025 оны 11 дүгээр сарын Б/13 “БНСУ-д албан томилолтоор ажиллуулах тухай” тушаалын дагуу БНСУ-ын “Чөжү 4х3 Энхтайван сан”-гийн урилгын дагуу ижил төрлийн үйл ажиллагаа явуулдаг байгууллагын хамтын ажиллагааны санамж бичгийн хүрээнд зохион байгуулагдах арга хэмжээнд ЦАУЗБУК-ын нарийн бичгийн дарга, орчуулагч нар 2025 оны 12 дугаар сарын 18-нас эхлэн 12 дугаар сарын 21-ний өдрүүдэд ажилласан. Гадаад албан томилолтын зардлаас 3.9 сая төгрөгийг, бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардлаас орчуулагчийн зардлыг 3.9 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Улс төрийн хэлмэгдүүлэлтийн түүх өнөө үеийн хандлага, хор уршиг, үр дагаврыг арилгах, соён гэгээрүүлэх нөлөөллийн чиглэлээр хэрэгжүүлж буй ажлын сайн туршлага солилцох, гадаадын ижил төрлийн мэргэжлийн байгууллагатай хамтын ажиллагааны хүрээнд БНСУ-д болсон Хэлмэгдэгчдийн дурсгалыг хүндэтгэх өдрийн арга хэмжээнд тус байгууллагын 2 албан хаагчийг “Чөжү 4х3 Энхтайван сан”-гийн санхүүжилтээр оролцуулжээ. Уг арга хэмжээнд гадаад албан томилолтын зардлаас 1.1 сая төгрөгийг зарцуулсан байна.

4. Тайлант хугацаанд хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх зардалд 2.8 сая төгрөгийг баталсныг Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуулийн нэмэлт өөрчлөлтийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Аймаг, нийслэл, дүүргүүдийн Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах салбар комиссын удирдах ажилтны сургалт зөвлөгөөнийг зохион байгуулжээ.
5. “Хамаг монгол бүү мартагтун” төслийн хүрээнд хийгдсэн цуврал /10-25/ минутын нэвтрүүлэг, мэдээ, мэдээлэл, комикс, ярилцлагыг олон нийтийн мэдээллийн хэрэгсэл болон цахим орчноор дамжуулан иргэдэд хүргэх ажлын хүрээнд 2025 онд 2 хуулийн этгээдтэй 10.5 сая төгрөгийн гэрээ байгуулан гүйцэтгүүлжээ.
6. ЦАУЗБУК-т төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой гарсан зардал байхгүй болно.

### 3.5.3 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны бараа, ажил, үйлчилгээ худалдан авах төлөвлөгөөг боловсруулж, батлаагүй байна. Тайлант онд 63.6 сая төгрөгийн дараах 4 ажил үйлчилгээг шууд гэрээ байгуулж, гүйцэтгүүлсэн байна. Үүнд:

1. Монгол Улсын нутаг дэвсгэрт улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгаж нэр төрийг нь сэргээх, тэдэнд нөхөх олговор олгох, улс төрийн хэлмэгдүүлэлтийн бусад үр дагаврыг арилгахтай холбогдсон харилцаанд хэрэгжиж буй үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлэх, хэлмэгдэгчдийн мэдээллийн сан бий болгох хэрэгцээг тодорхойлж, шаардлагатай программ, хангамжийн ажлын даалгавар боловсруулах зөвлөх үйлчилгээг 19.7 сая төгрөгөөр;
2. “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу үнэлгээ хийж хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох судалгааны ажлыг 19.1 сая төгрөгөөр;
3. Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах, хэлмэгдүүлэлтийн бусад үр дагаврыг арилгах, хэлмэгдүүлэлтийн хор уршгийг таниулах, ард иргэд, олон нийтийг соён гэгээрүүлэх ажлын хүрээнд 15 минутын баримтат ярилцлага бэлтгэх ажлыг 13.5 сая төгрөгөөр;
4. Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдүүлэлт ямар нэг хэлбэрээр давтагдахаас урьдчилан сэргийлэх, хүний эрхийг дээдлэх, дурсгалыг мөнхжүүлэх ажлын хүрээнд 10 ширхэг контент хийж гүйцэтгэх ажлыг 11.3 сая төгрөг;

### 3.5.4 Хөтөлбөр арга хэмжээний хүрэх үр дүн, хэрэгжилт

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн хавсралтаар баталсан тус ерөнхийлөн захирагчийн 2025 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээний зорилтот түвшнийг тусгасан байна. ЦАУЗБУК-ын 2025 оны ажлын үр дүнгийн гүйцэтгэл 97.0 хувьтай байна.

Хүснэгт 3. Хөтөлбөрийн чанарын болон тоо хэмжээний үзүүлэлт, хүрсэн үр дүн

№	Хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин	Үр дүн	
<b>72204 Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах үйл ажиллагаа</b>					
15.1	15.1.1	Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг олж тогтоох зорилгоор шалгах хэрэг материалын тоо	161	148	2025 онд мөрдөн шалгах ажиллагааны талаар тайлант хугацаанд нийт 202 хүнд холбогдох 148 хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулсан. Үүнд: - ТЕГ-ын тусгай архивын тасагт хадгалагдаж буй 158 хүнд холбогдох 127 эрүүгийн хэрэг, - Иргэдийн өргөдөл, гомдлоор 44 хүнд холбогдох 21 хэрэгт мөрдөн шалгах ажиллагааг явуулсан.
	15.1.2	Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөн олговор олгох тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсэгт заасан шүүхийн шийдвэр гарсан нэхэмжлэгчдэд нөхөн олговор олгох ажиллагаанд	8	7	Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөн олговор олгох тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.2-т зааснаар 41.0 сая болон 81.0 сая төгрөгийн нөхөн олговрыг нийт 7 иргэнд 322.0 сая төгрөгийн нөхөн олговрыг олгосон байна.

		хамрагдсан хүний тоо			
	15.1.3	Соён гэгээрүүлэх олон талт үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлж, хэлмэгдүүлэлт давтагдахаас урьдчилан сэргийлнэ.			
	15.1.3.1	“Хэлмэгдэгчдийн дурсгалд зориулах ногоон төгөл”-ийг байгуулах аймаг, нийслэлийн салбар комисс	5	2	Тайлант онд Улсын комиссын төсөвт энэ чиглэлийн үйл ажиллагаанд зориулсан төсөв тусгагдаагүй бөгөөд аймаг орон нутгийн өөрийн хөрөнгөөр “Ногоон төгөл”-ийг тохижуулсан байна. Харин Улсын комисс, Нийслэлийн салбар комисс, Чингэлтэй дүүргийн салбар комисс хамтран Хэлмэгдэгчдийн дурсгалын төв хөшөөний засварын ажлыг хийж гүйцэтгэжээ. Мөн Сонгинохайрхан дүүргийн Хамбын овооны дурсгалт газар төрийн бус байгууллага, хувь иргэнтэй хамтран мод тарьсан байна.
	15.1.3.2	Соён гэгээрүүлэх чиглэлээр бэлтгэх мэдээллийн тоо	5	4	Хуулиар хүлээсэн чиг үүргийн хүрээнд Улсын комиссын даргын санаачлан гаргасан богино хэмжээний нэвтрүүлэг 1 ширхэг, олон нийтэд хэлмэгдлийн хор уршгийг таниулах зорилготой контент 10 ширхэг, Хэлмэгдсэн Алтан ургийнхны талаарх судалгаа 1 ширхэг, Л.Лааганы амьдрал ба хэлмэгдүүлэлт ном зэргийг олон нийтийн хүртээл болгожээ.

#### 4. АУДИТЫН ТАЙЛАН

##### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу ЦАУЗБУК-ын даргын төсвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн ЦАУЗБУК, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн ЦАУЗБУК-ын санхүүгийн үйл ажиллагааг сайжруулах анхан шатны баримтын бүрдлийг хангах, үндсэн хөрөнгө, бараа материал, төсвийн хэмнэлттэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Б.Ариунжаргал, аудитор Д.Номингуа нар гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер А.Цогбаяр, Тусгай чиг үүргийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Баярсайхан нар тус тус хэрэгжүүлсэн.

ЦАУЗБУК-ын даргын төсвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2026 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн 55 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

## 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 8,334.4 сая төгрөгөөс 1.0 хувиар тооцож, 83.3 сая төгрөгөөр тогтоосон.

Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөн олговор олгох тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2<sup>1</sup>-т заасны дагуу шүүхийн шийдвэр гарсан нэхэмжлэгчдэд олгосон нөхөх олговрын хэмжээ өмнөх оноос 95.6 хувь буюу 7,080.3 сая төгрөгөөр (өмнөх онд 156 иргэнд нөхөх олговор олгож байсан бол тайлант онд 7 иргэнд олгож, 149 иргэнээр буурсан) буурсан тул 2025 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,216.2 сая төгрөгөөс 1.0 хувиар тооцож, 12.2 сая төгрөгөөр шинэчлэн тогтоолоо.

## 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулиар төсвийн байгууллага, түүний албан тушаалтны зарим үйл ажиллагаа, хангамжийг хязгаарласантай холбогдуулан төсвийн төслийн саналаар хүргүүлсэн зарим зардлыг татаж баталсан, аудитаар хэрэгжүүлсэн горим сорилын хүрээнд хуулийн хэрэгжилтийг хангаж ажилласан байна.

## 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн аудитын асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн аудиттай холбоотой нийт 322.0 сая төгрөгийн 2 зөрчил илэрсэнд, 322.0 сая төгрөгийн зөрчлийг арилгах 1 албан шаардлагыг хүргүүлж, 1 зөрчлийг давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өгсөн.

### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим системд зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 1,330.2 сая төгрөгийн 33 гүйлгээг, 442.1 сая төгрөгийн зарлагын 21 гүйлгээг, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулахтай холбоотой нийт 470.4 сая төгрөгийн 33 тушаал, шийдвэрийг хугацаанд нь мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль, тогтоомжийн холбогдох заалтуудтай нийцсэн байна гэж дүгнэлээ.

<sup>1</sup> “Энэ хуулийн 23.1-д заасны дагуу орон сууц аваагүй улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчид дараах нөхөх олговрыг доор дурдсанаар олгоно: 13.2.1-д “улс төрийн хилс хэрэгт холбогдуулан цаазаар авах ялаар шийтгүүлсэн хэлмэгдэгчийн эхнэр /нөхөр/, эсхүл хэлмэгдэгчийн төрсөн болон үрчилж авсан хүүхэд, хэлмэгдэгчийг нас барснаас хойш 10 сараас илүүгүй хугацааны дотор төрсөн хүүхдэд 80.0 сая төгрөг;”, 13.2.2-д “улс төрийн хилс хэрэгт холбогдуулан хорих ялаар шийтгүүлсэн хэлмэгдэгч, хэлмэгдэгч нас барсан бол түүний эхнэр /нөхөр/, эсхүл хэлмэгдэгчийн төрсөн болон үрчилж авсан хүүхэд, хэлмэгдэгчийг нас барснаас хойш 10 сараас илүүгүй хугацааны дотор төрсөн хүүхдэд 40.0 сая төгрөг.”

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

##### Албан шаардлага

1. Тайлант онд улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох зардалд 7 нэхэмжлэгчид нийт 322.0 сая төгрөгийг олгосныг холбогдох журамд заасны дагуу олон нийтэд мэдээлээгүй, мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлээгүй байна.

2. Тус байгууллага нь улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдэд нөхөх олговор олгохтой холбоотойгоор гаргасан нэхэмжлэл, тэдгээрийг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэр, олгосон нөхөх олговрын талаарх мэдээллийг нэгтгэн хөтөлсөн улсын хэмжээний нэгдсэн бүртгэл, мэдээллийн сан одоог хүртэл бүрэн бүрдээгүй байна. Энэ нь цаашид хэлмэгчдийн гэр бүлийн гишүүд болон хамаатан садангууд өөрсдийн харьяа шүүхэд тус тусдаа нэхэмжлэл гаргаж, нөхөх олговрыг давхардуулан авах эрсдэлтэй байна.

Эдгээр зөрчлүүд нь Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Энэ хуулийн дагуу цагаатгагдсан хэлмэгдэгчийн овог, нэр, товч намтар, хэрхэн хэлмэгдүүлсэн болон цагаатгасан тухай төрийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр олон түмэнд үнэ төлбөргүй мэдээлнэ.", Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын Ажлын албаны дотоод журмын 3 дугаар зүйлийн 3.1.6-д "Нөхөх олговрын нэхэмжлэлийг хангаж гарсан анхан шатны шүүхийн шийдвэрийг "Мэдээллийн нэгдсэн сан"-д бүртгэж авах, бүртгэлээр хяналт тавих" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нөхөх олговрын нэхэмжлэлийг хангаж гарсан анхан шатны шүүхийн шийдвэрийг бүртгэх мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлээгүй, нөхөх олговор олгосон талаар холбогдох журамд заасны дагуу олон нийтэд мэдээлээгүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

##### Зөвлөмж:

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Илрүүлэлт 1: Тус байгууллагын 2022 онд батлагдсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь тухайн байгууллагын онцлогийг тусгаагүй, холбогдох хууль тогтоомжтой нийцээгүй, шинэчлэн баталж мөрдөх ажил хийгдээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх;", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-д "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг байгууллагын санхүү, төсвийн удирдлагын зарчим болон байгууллагын үйл ажиллагаанд нийцүүлэн шинэчлэн боловсруулж батлан хэрэгжүүлэх замаар санхүүгийн бүртгэл, тайлагналын үнэн зөв байдлыг хангаж ажиллах.

#### 4.5 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 4,286.3 сая төгрөгийн 9 зөрчил илрүүлснээс 4,194.4 сая төгрөгийн 6 албан шаардлага, 91.9 сая төгрөгийн 3 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж, гүйцэтгэл 100.0 хувьтай байна.

*Хүснэгт 4. Албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт*

*/сая төгрөг/*

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		Хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Албан шаардлага	6	4,194.4	6	4,194.4	100.0
Зөвлөмж	3	91.9	3	91.9	100.0
<b>Нийт дүн</b>	<b>9</b>	<b>4,286.3</b>	<b>9</b>	<b>4,286.3</b>	<b>100.0</b>

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Монгол Улсын нутаг дэвсгэрт улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийн цагаатгаж нэр төрийг нь сэргээх, тэдэнд нөхөх олговор олгох, улс төрийн хэлмэгдүүлэлтийн бусад үр дагаврыг арилгахтай холбогдсон харилцаанд хэрэгжиж буй үйл ажиллагааг олон нийтэд ил тод, нээлттэй болгох цахим хэлбэрт шилжүүлэх, хэлмэгдэгчдийн мэдээллийн сан бий болгох хэрэгцээг тодорхойлж, шаардлагатай программ хангамжийн ажлын даалгавар боловсруулсан тул дараагийн аудитаар мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлсэн эсэхэд аудитын горим сорил хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа<sup>2</sup> илрээгүй болно.

Аудитаар нийт 44.2 сая төгрөгийн зөрчил<sup>3</sup> илэрснээс 39.1 сая төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага, 5.1 сая төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж өгсөн.

Залруулагдаагүй нийт 44.2 сая төгрөгийн алдаа, зөрчил нь тогтоосон материаллаг байдлын түвшнээс 32.0 сая төгрөгөөр давсан тул “**Хязгаарлалттай**” дүгнэлт өглөө.

### 5.1 Албан шаардлага

5.1.1. Үйл ажиллагааны чиглэл нь өөр аж ахуйн нэгжтэй ажил үйлчилгээ гүйцэтгүүлэх гэрээ байгуулж, нийт 13.5 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна. Үүнд:

- Худалдааны зуучлал, онлайн худалдаа, хэвлэх үйлдвэр, аялал жуулчлалын үйл ажиллагааны чиглэл бүхий компаниар “Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдүүлэлт ямар нэг хэлбэрээр давтагдахаас урьдчилан сэргийлэх, хүний эрхийг дээдлэх, дурсгалыг мөнхжүүлэх ажлын хүрээнд 10 ширхэг контент” бэлтгэх ажлыг гэрээгээр гүйцэтгүүлж 11.3 сая төгрөг;
- Бэлэг дурсгалын зүйлсийн худалдаа, хэвлэх үйлдвэр, интерьер дизайн хийх, тавилгын үйлдвэрлэл, соёл урлагийн арга хэмжээ зохион байгуулах, барилгын засвар хийх, тавилгын худалдаа үйл ажиллагааны чиглэл бүхий компаниар компьютерын сэлбэг худалдан авах, серверийн засвар үйлчилгээ хийлгэхэд нийт 2.2 сая төгрөг зарцуулсан.

Эдгээр зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх;", 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.2.4-д “үйл ажиллагааны салбар, газар зүйн байрлалд үндэслэн захиалагчийг тодорхойлсон байх.” заалтуудыг тус тус хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Үйл ажиллагааны чиглэл нь өөр аж ахуй нэгж, байгууллагатай гэрээ байгуулан санхүүжилт олгосон зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлсэн.

5.1.2. Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийн дурсгалыг хүндэтгэн өнгөрүүлэх 30 дахь удаагийн арга хэмжээг зохион байгуулах ажлын хүрээнд "Хэлмэгдэгчдийн дурсгалыг хүндэтгэх төв хөшөө"-нд засвар хийх ажлыг "Моок дизайн инженеринг" компаниар гүйцэтгүүлж, 10.5 сая төгрөгийг зарцуулахдаа анхан шатны баримтын бүрдэл дутуу, нотлох баримтын шаардлага хангаагүй байхад зарцуулсан нь бүртгэлээр тавих дотоод хяналтыг бүрэн хэрэгжүүлээгүйтэй холбоотой байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх;", 41.2.6-д "төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэлийн санхүүжилтийг бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны гэрээ, төлбөрийн хуваарийг үндэслэн санхүүжүүлэх;", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.", 20 дугаар зүйлийн 20.1.4-т "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" заалтуудыг хэрэгжүүлээгүй байна.

<sup>2</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>3</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Шийдвэрлэсэн нь: Анхан шатны баримтын бүрдэл дутуу, нотлох баримтын шаардлага хангаагүй баримтаар ажил, гүйлгээг бүртгэн тайлагнасан зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

5.1.3. Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 11 нэр төрлийн нийт 15.1 сая төгрөгийн хөрөнгийн асуудлыг ТӨБЗГ-т тавьж шийдвэрлүүлэх арга хэмжээ аваагүй байна. Үүнд: Ашиглалтын хугацаа дуусаагүй байхад элэгдэх өртгөө нөхсөн 3 нэр төрлийн 5.7 сая төгрөгийн машин тоног төхөөрөмж, ашиглалтын хугацаа дууссан 8 нэр төрлийн 10 ширхэг 9.4 сая төгрөгийн машин тоног төхөөрөмж байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дугаар зүйлийн 3-д "2/ илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох;", ТӨБЗГ-ын 2019 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн 271 дугаар тогтоолоор баталсан Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журмын 7.1-т "Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ" заалтуудыг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгийг ТӨБЗГ-т хандаж шийдвэрлүүлээгүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

## 5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

*Илрүүлэлт 1:* Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 05 дугаар даалгаврыг зөрчин контент бүтээх, үүлэн технологид хадгалах, засварлах, онлайн хурал, зөвлөгөөн зохион байгуулах зэрэг ажлуудыг хийхэд шаардлагатай программуудын 1 жилийн эрхийг 2025 оны 12 дугаар сарын 24-ний өдөр худалдан авахад зориулж 5.1 сая төгрөгийг зарцуулсан.

Энэ нь Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 05 дугаар "Төсвийн сахилга бат, хариуцлагыг чангатгах" 1.4.4. "гуравдагч этгээдээр гүйцэтгүүлэх мэргэжлийн болон зөвлөх үйлчилгээний гэрээ шинээр байгуулахгүй байх", 1.4.5. "төрийн байгууллагын хэрэгжүүлдэг төсөл, хөтөлбөр, арга хэмжээний зардлын санхүүжилтийг дараагийн төсвийн жилд шилжүүлэх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийн сахилга бат, хариуцлагыг чангатгах тухай албан даалгаврыг мөрдөж ажиллах зөвлөмжийг өгсөн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### 6.1 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:									
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13
Үйл ажиллагааны чиглэл нь өөр аж ахуйн нэгжтэй ажил үйлчилгээ гүйцэтгүүлэх гэрээ байгуулж, нийт 13.5 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон.	1	13.5			1	13.5						
Анхан шатны баримтын бүрдэл дутуу, нотлох баримтын шаардлага хангаагүй байхад "Хэлмэгдэгчдийн дурсгалыг хүндэтгэх төв хөшөө"-нд засвар ажилд 10.5 сая төгрөгийг зарцуулсан нь бүртгэлээр тавих дотоод хяналтыг бүрэн хэрэгжүүлээгүйтэй холбоотой байна.	1	10.5			1	10.5						
Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн нийт 15.1 сая төгрөгийн хөрөнгийн асуудлыг ТӨБЗГ-т тавьж шийдвэрлүүлэх арга хэмжээ аваагүй.	1	15.1			1	15.1						
Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 05 дугаар даалгаврыг хэрэгжүүлээгүй контент бүтээх, үүлэн технологид хадгалах, засварлах, онлайн хурал, зөвлөгөөн зохион байгуулах зэрэг ажлуудыг хийхэд	1	5.1							1	5.1		

Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын 2025 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

шаардлагатай программуудын 1 жилийн эрхийг 2025 оны 12 дугаар сарын 24-ний өдөр худалдан авахад зориулж 5.1 сая төгрөгийг зарцуулсан.												
<b>Дүн</b>	<b>4</b>	<b>44.2</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>3</b>	<b>39.1</b>			<b>1</b>	<b>5.1</b>	<b>-</b>	<b>-</b>

**6.2 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/сая төгрөгөөр/

Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9
1.Тайлант онд улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох зардалд 7 нэхэмжлэгчид нийт 322.0 сая төгрөгийг олгосныг холбогдох журамд заасны дагуу олон нийтэд мэдээлээгүй, улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдэд нөхөх олговор олгохтой холбоотойгоор гаргасан нэхэмжлэл, тэдгээрийг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэр, олгосон нөхөх олговрын талаарх мэдээллийг нэгтгэн хөтөлсөн улсын хэмжээний нэгдсэн бүртгэл, мэдээллийн сан одоог хүртэл бүрэн бүрдээгүй.	1	322.0			1	322.0		
Тус байгууллагын 2022 онд батлагдсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь тухайн байгууллагын онцлогийг тусгаагүй, холбогдох хууль тогтоомжтой нийцээгүй, шинэчлэн баталж мөрдөх ажил хийгдээгүй.	1	-					1	-
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>322.0</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>322.0</b>	<b>1</b>	<b>-</b>



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 04 сарын 24 өдөр

Дугаар 1301/А0111371

Улаанбаатар хот

САГ-2026/27/НА-СТА-ТЭЗ

Зөрчлийг таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Үйл ажиллагааны чиглэл нь өөр аж ахуйн нэгжтэй ажил үйлчилгээ гүйцэтгүүлэх гэрээ байгуулж, нийт 13,500,000.00 /арван гурван сая таван зуун мянга/ төгрөгийн санхүүжилтийг олгосон байна. Үүнд:

1.Худалдааны зуучлал, онлайн худалдаа, хэвлэх үйлдвэр, аялал жуулчлалын үйл ажиллагааны чиглэл бүхий компаниар “Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдүүлэлт ямар нэг хэлбэрээр давтагдахаас урьдчилан сэргийлэх, хүний эрхийг дээдлэх, дурсгалыг мөнхжүүлэх ажлын хүрээнд 10 ширхэг контент” бэлтгэх ажлыг гэрээгээр гүйцэтгүүлж 11,300,000.00 /арван нэгэн сая гурван зуун мянга/ төгрөг;

2.Бэлэг дурсгалын зүйлсийн худалдаа, хэвлэх үйлдвэр, интерьер дизайн хийх, тавилгын үйлдвэрлэл, соёл урлагийн арга хэмжээ зохион байгуулах, барилгын засвар хийх, тавилгын худалдаа үйл ажиллагааны чиглэл бүхий аж ахуйн нэгжээр компьютерын сэлбэг худалдан авах, серверийн засвар үйлчилгээ хийлгэхэд нийт 2,200,000.00 /хоёр сая хоёр зуун мянга/ төгрөг зарцуулсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх;" 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно." Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.2.4-т "үйл ажиллагааны салбар, газар зүйн байрлалд үндэслэн захиалагчийг тодорхойлсон байх." гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Үйл ажиллагааны чиглэл нь өөр аж ахуйн нэгж, байгууллагатай гэрээ байгуулан санхүүжилт олгосон зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын дарга Б.Пүрэвдорж, нарийн бичгийн дарга /Ч.Цасчихэр/, нягтлан бодогч /Х.Хажидмаа/ нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**  
МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОР





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 04 сарын 24 өдөр

Дугаар 1302/А0111371

Улаанбаатар хот

САГ-2026/27/НА - СТА - ТЭЗ

Зөрчлийг арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийн дурсгалыг хүндэтгэн өнгөрүүлэх 30 дахь удаагийн арга хэмжээг зохион байгуулах ажлын хүрээнд "Хэлмэгдэгчдийн дурсгалыг хүндэтгэх төв хөшөө"-нд засвар хийх ажлыг "Моок дизайн инженеринг" компаниар гүйцэтгүүлж 10,520,000.00 /арван сая таван зуун хорин мянга/ төгрөгийн анхан шатны баримтын бүрдэл дутуу, нотлох баримтын шаардлага хангаагүй байхад зарцуулсан нь бүртгэлээр тавих дотоод хяналтыг бүрэн хэрэгжүүлээгүйтэй холбоотой байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 41.2.6-д "төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэлийн санхүүжилтийг бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны гэрээ, төлбөрийн хуваарийг үндэслэн санхүүжүүлэх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.", 20 дугаар зүйлийн 20.1.4-т "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Анхан шатны баримтын бүрдэл дутуу, нотлох баримтын шаардлага хангаагүй байхад ажил, гүйлгээг бүртгэсэн зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын дарга Б.Пүрэвдорж, нарийн бичгийн дарга /Ч.Цасчихэр/, нягтлан бодогч /Х.Хажидмаа/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОР

С.МАГНАЙСҮРЭН



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 04 сарын 24 өдөр

Дугаар 1303/А0111371

Улаанбаатар хот

САГ-2026/27/НА-СТА-ТЭЗ

Зөрчлийг арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 11 нэр төрлийн нийт 15,129,800.00 /арван таван сая нэг зуун хорин есөн мянга найман зуу/ төгрөгийн хөрөнгийн асуудлыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт тавьж шийдвэрлүүлэх арга хэмжээ аваагүй байна. Үүнд: Ашиглалтын хугацаа дуусаагүй байхад элэгдлээрээ өртгөө нөхсөн 3 нэр төрлийн 5,719,500.00 /таван сая долоон зуун арван есөн мянга таван зуу/ төгрөгийн, ашиглалтын хугацаа дууссан 8 нэр төрлийн 9,410,300.00 /есөн сая дөрвөн зуун арван мянга гурван зуу/ төгрөгийн машин тоног төхөөрөмж бүртгэлтэй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах," Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дугаар зүйлийн 3-т "2/ илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох," Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн 271 дугаар тогтоолоор баталсан Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журмын 7.1-д "Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ" заалтуудыг хэрэгжүүлээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-26-230

Z:\Alban Shaardlaga\2026\0424 SAG-9.Docx

1526182063

1. Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгийн асуудлыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраар шийдвэрлүүлэх арга хэмжээ аваагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын дарга Б.Пүрэвдорж, нарийн бичгийн дарга /Ч.Цасчихэр/, нягтлан бодогч /Х.Хажидмаа/ нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**  
МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОР





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 04 сарын 24 өдөр

Дугаар 1304/АД111371

Улаанбаатар хот

САГ-2026/27/КА-СТА-ТЄЗ

Зөрчлийг арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөн олговор олгох зардалд 7 нэхэмжлэгчид нийт 322,000,000.00 /гурван зуун хорин хоёр сая/ төгрөгийг олгосныг холбогдох журамд заасны дагуу олон нийтэд мэдээлээгүй, мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлээгүй байна.

2. Тус байгууллага нь улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдэд нөхөн олговор олгохтой холбоотойгоор гаргасан нэхэмжлэл, тэдгээрийг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэр, олгосон нөхөн олговрын талаарх мэдээллийг нэгтгэн хөтөлсөн улсын хэмжээний нэгдсэн бүртгэл, мэдээллийн сан одоог хүртэл бүрэн бүрдээгүй байна. Энэ нь цаашид хэлмэгчдийн гэр бүлийн гишүүд болон хамаатан садангууд өөрсдийн харьяа шүүхэд тус тусдаа нэхэмжлэх гаргаж, нөхөн олговрыг давхардуулан авах эрсдэлтэй байна.

Энэ нь Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөн олговор олгох тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Энэ хуулийн дагуу цагаатгагдсан хэлмэгдэгчийн овог, нэр, товч намтар, хэрхэн хэлмэгдүүлсэн болон цагаатгасан тухай төрийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр олон түмэнд үнэ төлбөргүй мэдээлнэ.", Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын Ажлын албаны дотоод журмын 3 дугаар зүйлийн 3.1.6-д "Нөхөн олговрын нэхэмжлэлийг хангаж гарсан анхан шатны шүүхийн шийдвэрийг "Мэдээллийн нэгдсэн сан"-д бүртгэж авах, бүртгэлээр хяналт тавих" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Нөхөн олговрын нэхэмжлэлийг хангаж гарсан анхан шатны шүүхийн шийдвэрийг бүртгэх мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлээгүй, нөхөн олговор олгосон талаар холбогдох журамд заасны дагуу олон нийтэд мэдээлээгүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын дарга Б.Пүрэвдорж, нарийн бичгийн дарга /Ч.Цасчихэр/, нягтлан бодогч /Х.Хажидмаа/ нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**  
МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОР



**С.МАГНАЙСҮРЭН**